



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

「Зочид буудал, дэн буудал, амралтын газар,  
жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан таван аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан долоон иргэн, аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын тавдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Манкур” ХХК-ийн “Манкур” дэн буудлын 13/102 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

7. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

8. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.


ДАРГА



Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 22  
өдрийн 1709 тоот тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Уран ган ХХК	Уранган	Баянгол дүүрэг, 3-р хороо, Дунд голын хойд эрэг

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 22  
өдрийн 109 тоот тушаалын хоёрдугаар  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2015.09.22


Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Тэрэлж сүйх ХХК	Тэрэлж	Налайх хот, 6-р хороо, Жо Вангийн адагт
2	Ундруул сифан ХХК	Ундруул	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Энхтайваны өргөн чөлөө зүүн 4 зам
3	Зорголын гүнж ХХК	Декор	Баянгол дүүрэг, 4-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 93
4	Жи Би Эс импекс ХХК	Хабу	Баянгол дүүрэг, 1-р хороо, Замчдын гудамж 48а
5	Зул Оюу ХХК	Би энд Жи	Баянзүрх дүүрэг, 13-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 123

-ооОоо-



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 22  
өдрийн 109 тоот тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Манкур ХХК	Манкур	Баянгол дүүрэг, 16-р хороо, Туулын 19/386 /захирлын нэр өөрчлөгдсөн/

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 22  
өдрийн 139 тоот тушаалын дөрөвдүгээр  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2015.09.22


Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн П.Анхмаа	Роял	Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Өлгийн 10/153
2	Ачнууд ХХК	Санни	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Дандар Баатарын гудамж
3	Ригнесс ХХК	Халиун	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, нуурын 8/94
4	Хөх молор ХХК	Молор	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Дандар Баатарын гудамж
5	Хөх Тэнгэрийн заяа ХХК	Доллар	Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн 75
6	Иргэн Д.Рэгээдмаа	Филимон	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 386
7	Оасис Мон ХХК	Оасис	Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Чулуутын 1/10

-ooOoo-



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 05 сарын 22  
өдрийн 109 тоот тушаалын тавдугаар  
хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2015.09.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Элма Баян-Уул ХХК	Баян-Уул	Сонгинохайрхан дүүрэг, 24-р хороо, Толгойтын баруун салаа.

-ооОоо-